



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/196

Номгон


Төрийн архивын баримтыг цахим санд
шилжүүлэх бэлтгэх ажлыг эрчимжүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 м, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.2, Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөны 102 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн архивын сан хөмрөгийн баримтыг цахим санд шилжүүлэхэд бэлтгэх Иж бүрэн нягтлан шалгах хөтөлбөрийн үйл ажиллагааг эрчимжүүлсүгэй.

2. Үйл ажиллагаанд зарцуулах 3.000.000 (Гурван сая) төгрөгийг аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3.Иж бүрэн нягтлан шалгах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Архивын тасаг (В.Эрдэнэчимэг), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН